

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН СУДАЛГАА

THE OPERATIONAL RISK SURVEY OF SMALL AND MEDIUM ENTERPRISES

Ж.Соёлмаа*

Дотоод хэргийн их сургуулийн Эдийн засгийн аюулгүй байдлын магистрант
Soyolmaa J, MA Scholar in Economic Security, University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: soyolmaa.j@capitronbank.mn

Хураангуй: Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, эрсдэлийг судалж, улмаар жижиг, дунд үйлдвэрүүдийг чадавхжуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход оршино. Жижиг, дунд үйлдвэрлэгчдээс санал асуулгын судалгааг Face to Face, хослуулсан хэлбэрээр гүйцэтгэсэн бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, ажилтан нараас Фокус группийн аргаар судалгааг гүйцэтгэв. Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг эксел программаар гүйцэтгэж, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт оролцогч талуудын хүч нөлөөний шинжилгээг SAM шинжилгээний арга зүйгээр, харин тулгамдсан байдал, давуу ба сул талыг Cross SWOT шинжилгээний арга зүйгээр боловсруулж, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг богино, дунд, урт хугацаанд тодорхойлов. Жижиг, дунд үйлдвэрүүдийн тулгамдсан асуудлуудын нэгдүгээрт, “Гадаад зах зээлд гаргах бүтээгдэхүүний чанар, стандарт, хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа байхгүй” гэсэн бол дараа нь “Маркетинг, бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлийн талаарх мэдлэг муу”, “Экспортын талаарх мэдлэг сул”, “Ажиллах хүчний ур чадвар, дутагдал”, “Санхүүжилт дутагдалтай” хэмээн эрэмбэллээ. Иймд үйлдвэрлэгчдэд гадаад зах зээлийн чанар, стандарт, хэрэглэгчийн зан төлөвийн мэдлэг, мэдээллийг олгох судалгаанд үндэслэсэн сургалтыг зохион байгуулах, гадаад зах зээлийн борлуулалтын сувагтай тэднийг холбох зөвлөх үйлчилгээ, экспортын талаар мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулах нь ач холбогдолтой байна.

Abstract: The purpose of the research is to study the current state and risks of small and medium-sized enterprises operating in Ulaanbaatar city and define the needs and requirements for enhancing the capacity of these enterprises. The research was conducted through face-to-face interviews with small and medium-sized enterprises and through the use of the Focus group method among experts and employees responsible for small and medium enterprises. The research results have been processed with the Excel program, and the influence analysis of participants in the small and medium enterprises sector was performed using the SAM analysis method, while significant issues, strengths, and weaknesses were analyzed through the Cross SWOT methodology. The proposed work plan was further defined in the short, medium, and long term. The first significant issues faced by small and medium enterprises are “lack of research on the quality, standards, and consumer behavior of products intended for foreign markets,” followed by “poor knowledge about marketing and selling products in the market”, “weak knowledge about exports”, “workforce skills and deficiency” and “lack of funding.” Therefore, it is important to organize training based on research that provides enterprises with knowledge and information about the quality, standards, and consumer behavior in foreign markets, offering consulting services to connect them with export sales channels, and organizing training to improve knowledge about exports would be significantly beneficial.

Түлхүүр үгс: Үйлдвэрийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны эрсдэл, SAM шинжилгээ, үйлдвэрийн тулгамдсан асуудал

Keywords: Enterprises operation, operational risks, SAM analysis, problems of SME enterprises



Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, эрсдэлийг судалж, улмаар жижиг, дунд үйлдвэрүүдийг чадавхжуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход оршино.



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

Удиртгал

Төрөөс жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хууль (УИХ, 2019), Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр (Монгол Улсын Засгийн газар, 2019), Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн журам (Монгол Улсын Засгийн газар, 2020), ЖДҮГ-ийн Стратеги төлөвлөгөө (ЖДҮГ, 2024)-ний хэрэгжилтийн түвшин доогуур, нөгөө талаас, нийт аж ахуйн нэгжийн 77 хувь, нийт ажиллах хүчний 72 хувийг эзэлж байгаа ч өрсөлдөх чадварын түвшин доогуур, өрхийн амьжиргаанд дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй байгаа тул энэхүү сэдвийн хүрээнд судалгаа хийсэн болно.

Судалгааны ажлын хүрээнд жижиг, дунд үйлдвэрүүдийг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилж хязгаарлалт хийгээгүй, харин байршлаар нь буюу Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 351 жижиг, дунд үйлдвэрлэгчдийг хамруулав.

Жижиг, дунд үйлдвэрлэгчдээс гадна Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрийн газрын мэргэжилтэн нар, ХХБ-ны ажилтан нартай фокус группийн тус бүр нэг, нийт 2 фокус группийн ярилцлагыг зохион байгууллаа. Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрийн газартай хамтарч гүйцэтгэсэн судалгаанд 248 үйлдвэрлэгч хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагсдын 49.2 хувь нь эрэгтэй, 50.8 хувь нь эмэгтэй байв.

Жижиг, дунд үйлдвэрлэгчдээс санал асуулгын судалгаа болон Face to Face аргаар, хослуулсан хэлбэрээр гүйцэтгэсэн бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, ажилтан нараас Фокус группийн аргаар судалгааг гүйцэтгэв. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдээс үйл ажиллагааных нь талаар 1-10 баллаар өөрсдөөс нь үнэлгээг авч оноожуулж


тодорхойлов. Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг эксел программаар гүйцэтгэж, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт оролцогч талуудын хүч нөлөөний шинжилгээг SAM шинжилгээний арга зүйгээр, харин тулгамдсан байдал, давуу ба сул талыг Cross SWOT шинжилгээний арга зүйгээр боловсруулж, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг богино, дунд, урт хугацаанд тодорхойлов.

Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнгээс харахад, 10.2 хувь нь 24 ба түүнээс дээш жил ажилласан, 32.5 хувь нь 14-23 жил ажилласан, 46.7 хувь нь 4-13 жил ажилласан, 10.7 хувь нь 2-3 жил ажилласан туршлагатай байна. Жижиг, дунд үйлдвэрүүдэд тулгарч болох эрсдэл нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардагдах орц, түүхий эдийн хангалт, олдоц юм. Судалгаанд оролцогчдын 61.7 хувь нь үндсэн түүхий эдээ импортоор авдаг бол үлдсэн хувь нь импортолдоггүй. Уг асуултад “тийм” хэмээн хариулсан жижиг, дунд үйлдвэрүүдийн 71.2 хувь нь “4-7 оноо”-г өгсөн нь импортын түүхий эдийн олдоц дундаж үнэлгээтэй байна. Судалгааны үр дүнд импортын орцын хүртээмж бага байна. Жижиг, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэл нь импортын орцоос хамааралтай. Иймд цаашид үйлдвэрлэл эрхлэгчдийн импортоос хамаарах хамаарлыг багасгах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах импортын орцыг дотоодын орцоор орлуулах, сав баглаа боодол гэх мэт орцуудыг дотооддоо үйлдвэрлэх хэрэгтэй юм.

Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн экспортод чиглэсэн бүтээгдэхүүн явуулж буй эсэхийг судалгааны ажлын хүрээнд судаллаа.

Экспорт хийсэн эсэх



Экспортын борлуулалтын орлогод эзлэх хувь




График 1. Экспорт. Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнд, үйлдвэрлэл эрхлэгчдийн 56.2 хувь нь бүтээгдэхүүнээ экспортолжээ. Эндээс харахад, жижиг, дунд үйлдвэрлэгчдийн бараг тал хувь нь экспорт хийдэг байна. Харин үлдсэн хэсэг нь экспорт хийгээгүй буюу зөвхөн дотоод зах зээлд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

Экспорт хийдэг жижиг, дунд үйлдвэрлэгчдээс бүтээгдэхүүнийхээ хэдэн

хувийг экспортолдог болохыг тодруулахад, 60.8 хувь нь “30.0 хүртэлх хувийг”, 37.8 хувь нь “31.0-75.0 хувийг”, 1.4 хувь нь “75.0 хувиас дээш” хувийг экспортолдог. Экспорт хийсэн үйлдвэрүүдийн 3/4 нь ноолуурын салбарт үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь жижиг, дунд үйлдвэрийн хөгжилд үйл ажиллагаа явуулж буй тухайн салбарын хөгжил хамаатайг илтгэнэ.

Орлогын хэмжээ	2021	2022	2023
50 саяас доош	60.7%	35.6%	29.5%
51-100 сая	7.1%	9.6%	14.3%
101-300 сая	7.1%	20.5%	14.3%
301-1 тэрбум	17.9%	19.2%	29.5%
1 тэрбумаас дээш	7.1%	15.1%	12.4%
Хамгийн их орлогын хэмжээ, ₮	5,594,782,190	4,100,000,000	5,000,000,000
Хамгийн бага орлогын хэмжээ, ₮	4,000,000	4,000,000	4,500,000

Хүснэгт 1. Жижиг, дунд үйлдвэрүүдийн борлуулалтын орлого /хувиар, ₮/ Эх үүсвэр: Судалгааны үр дүн

2021 онд жижиг, дунд үйлдвэрүүдийн 60.7 хувь нь 50.0 сая төгрөгөөс доош борлуулалтын орлоготой байсан. Харин 2023 онд энэ нь буурч 29.5 хувь болжээ. сүүлийн 3 жилд 51-100 сая, 101-300 сая, 300 саяас 1 тэрбум төгрөгийн орлоготой аж ахуйн нэгжүүдийн тоо өссөн. Энэхүү өсөлт нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдаатай ч Засгийн газраас авч хэрэгжүүлсэн “10 их

наяд” хөтөлбөр дэмжлэгүүдийн үр дүн гэж үзэж болох талтай.

Судалгаанд хамрагсад өөрийн эрхэлж буй бизнесийн хөгжлийн өнөөгийн түвшинд доогуур буюу 5 оноонд ч хүрээгүй юм. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид өөрийн үйл ажиллагаандаа сэтгэл хангалуун бус байна. Тэдний үйл ажиллагааны хэтийн төлөвт өгсөн үнэлгээг дараах зургаар харуулав.



МОНГОЛЫН
Дотоод
Хэрэг
Яам



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠤᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ




График 2. Жижиг, дунд бизнесийн хэтийн төлөв \үйлдвэрлэл эрхлэгчдийн өөрсдийн үнэлгээ\ Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Жижиг, дунд бизнес эрхлэгчид өөрийн үйл ажиллагааг доогуур түвшинд буюу 3.3 оноо өгсөн нь итгэл сул байгааг харуулж байна.

Жижиг, дунд үйлдвэрүүдэд ямар хүндрэл, бэрхшээлүүд байгааг судалгааны явцад асууж лавласан болно.




График 3. Үйлдвэрлэл эрхлэгчдийн тулгамдсан асуудлууд Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Үйлдвэрлэл эрхлэгчид эргэлтийн хөрөнгийг худалдан авах санхүүгийн бэрхшээлтэй, олдоц тогтмол бус, ховор байдаг гэж нэрлэснээс гадна ажиллах хүч дутагдалтай, цалингийн зардал өндөр хувь эзэлдэг хэмээсэн. Үүний дараа нь хууль, эрх зүйн акт, бичиг баримтууд байдаг хэдий ч тэдгээрийг хэрхэн хэрэглэх мэдээлэл, мэдлэг муу байгааг нэрлэлээ.

Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлс нь эргэлтийн хөрөнгийн дутагдал (16.8%), ажиллах хүчний дутагдал (14.5%) гэж хариуллаа. “Борлуулах зах зээлийн мэдлэг, мэдээлэл дутмаг” гэсэн хариултад гадаад зах зээлд борлуулах мэдлэг байхгүй, борлуулах түншлэгч байхгүй, гадаад зах зээлтэй холбогдоогүй гэсэн хариултаудыг нэгтгэвэл 11.0 хувь буюу гуравдугаарт эрэмбэлэгдэж байна. Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй (8.2%) гэсэн хариултад хууль эрх, зүйн акт, бичиг баримтыг хэрэглэж мэддэггүй, энэ талын мэдлэг дутмаг байдлыг хамтатган ойлгож болно. Тээвэр ложистикийн сул хөгжил (7.0%) хариултад, зөвхөн гадаад тээвэр ложистикийг хэлээгүй бөгөөд орц, гарцын тээврийн хүртээмж бага, үнэ ханш өндөр гэдгийг илэрхийлж байв. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн дутагдал (6.3%), гаалийн татвар өндөр (6.3%), хөрөнгө оруулалтын эх үүсвэр дутагдалтай (4.7%), төрийн дэмжлэг дутагдалтай (3.5%) хэмээн нэрлэв.

Жижиг, дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагаа, хөгжилд нөлөөлж буй саад бологч хүчин зүйлс, дэмжигч хүчин зүйлсийг судалгаанд оролцогчдын нэрлэсэн хүчин зүйлсийн дагуу дор эмхэтгэв.




График 4. Жижиг, дунд үйлдвэрийн хөгжилд саад бологч болон дэмжигч хүчин зүйлс Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Үйлдвэрлэл эрхлэгчдийн тулгамдсан асуудлууд нь “Эргэлтийн хөрөнгийн хомсдол, санхүүжилт дутмаг байдал”, “Ажиллах хүчний дутагдал”, “Хууль, эрх зүйн зохицуулалт”, “Тээвэр, логистикийн сул хөгжил”, “Үйлдвэрлэлээ удирдах, өргөтгөх менежментийн мэдлэг муу” гэсэн асуудлууд байна.

Aubrey Mendelow, (1991) -ын боловсруулсан оролцогч талуудын матриц шинжилгээ нь төслийн явцад хамаарагчдыг удирдах энгийн аргыг санал болгодог. Оролцогч талууд нь өөр өөр ашиг сонирхолтой байдаг бөгөөд үүнээс үүдэн үл ойлголцол, мөргөлдөөн үүсэж, цаашлаад төслийн үр дүн нь буурахад хүргэдэг. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд Менделовын матриц нь дараах хоёр хэмжээсийг ашиглан оролцогч талуудыг ангилжээ.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын оролцогч талууд болох Засгийн газар буюу Нийслэл болон орон нутгийн Жижиг, дунд үйлдвэрийн газар, орцыг нийлүүлэгч тал болох малчид, үйлдвэрлэгчдийн эрх ашгийн төлөөх байгууллага болох МҮХАҮТ болон мэргэжлийн холбоод, Хятадын ченжүүд, зарим орцыг нийлүүлэгч гадаадын компани, хувь хүмүүс, Олон улсын байгууллагууд, арилжааны банкнуудын оролцооны түвшнийг зургаар харуулав.



График 5. Жижиг, дунд бизнест оролцогч талын матриц шинжилгээ Эх үүсвэр: Судалгааны үр дүн



МОНГОЛЫН
Дотоод
Хэрэг
Яам



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Монгол Улсын Засгийн газар (Жижиг, дунд үйлдвэрийн газар): Монгол Улсын Засгийн газар жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын гол оролцогч тал бөгөөд бодлого, татвар, урамшуулал гэх мэт зохицуулалтаар дамжуулан тогтвортой хөгжлийг хангахад чиглэдэг. Монгол Улсын Засгийн газар жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих байр суурьтайгаар өдийг хүрсэн. Иймд Засгийн газар нь өндөр нөлөөтэй, өндөр ашиг сонирхол бүхий оролцогч тал юм. Жижиг, дунд үйлдвэрийн газар 2023 онд 27,387,703,081 ₮ зээлийг 208 зээлдэгчид олгож 1002 ажлын байрыг бий болгосон байдаг (Жижиг дунд үйлдвэрлэлийн газар, 2024).

Малчид: Малчид жижиг, дунд үйлдвэрүүдийн түүхий эд нийлүүлэгч чухал тоглогч юм. Тэд түүхий эд нийлүүлж, үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Малчид хоршоогоор дамжуулж мал аж ахуйг дэмжих, санхүүжүүлэх, сургах, бэлтгэх, хадгалах, борлуулах, түгээх зэрэг цогц үйлчилгээг авдаг. Зарим хоршоод мал эмнэлгийн нэгдсэн үйлчилгээ, түүхий эдийн сайжруулах, сайжруулах боломжийг санал болгодог. (The World Bank, 2003).

Хятадын ченжүүд: Хятадын худалдаачид Монголд маш идэвхтэй ажиллаж, малчдаас түүхий эдийг шууд худалдан авдаг бөгөөд Европын талуудтай харьцуулахад илүү давуу байдлыг эдэлдэг (United Nations Development Programme, 2019). Эдгээр ченжүүд ноолуурын салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрүүдэд хүчтэй нөлөө үзүүлдэг. Тухайлбал, Монголоос түүхий болон угаасан ноолуурыг Хятадын бага хүүтэй зээлээр худалдан авч, улмаар Хятадын боловсруулах үйлдвэрт экспортолдог тул ихээхэн нөлөө бүхий оролцогч тал юм.

Орц нийлүүлэгч гадаадын компани, хувь хүмүүс: Монголын жижиг, дунд үйлдвэрлэгчид бүтээгдэхүүн үйлдвэрлэх орцынхоо нэгээхэн хэсгийг гадаад улсаас, ялангуяа БНХАУ-аас импортолдог. Дотоодын орлого 1 хувиар нэмэгдэхэд импортын эрэлт 1.55 хувиар өсдөг бөгөөд импортын харьцангуй үнэ 1 хувиар өсөхөд

(гадаад үнэ дотоод үнээс өндөр өсөх эсвэл дотоод үнэ гадаад үнээс илүү ихээр буурах) импортын эрэлт 0.65 хувиар буурдаг байна (Дуламзаяа, 2018).

Арилжааны банкнууд: Арилжааны банкнууд зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, түүгээр дамжуулан бага хүүтэй зээл авах боломжтой жижиг, дунд үйлдвэрлэгчдэд санхүүжилт олгодог. 2021 онд арилжааны банкнууд 1 жилийн хугацаатай, гурван хувийн хүүтэй нийт 94.9 тэрбум хүртэлх төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн бөгөөд үүний 71.0 тэрбумыг нь олгосон байна (УИХ, 2021). Ерөнхийдөө арилжааны банкнууд тэр дундаа ХААН, Төрийн, ХХБ, Голомт банк нь малчин өрх, ченж, малчдын хоршоод, боловсруулах үйлдвэрүүдэд гол зээл олгогчийн хувьд жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт үзүүлэх нөлөөлөл өндөр байдаг.

Сүүлийн үед “ногоон зээл” хэмээх ойлголт хүчтэй дэлгэрч байгаатай холбоотойгоор тогтвортой санхүүгийн эх үүсвэрийг бий болгоход зээлийн байгууллагууд, ялангуяа Монголын арилжааны банкнууд анхаарал ихээр тавьж байна (Бакей, А., нар. 2024). Энэ тохиолдолд арилжааны банкнууд жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт өндөр нөлөөтэй бөгөөд өндөр сонирхолтой бүлэг гэж үзэх боломжтой юм.

МУХАҮТ болон мэргэжлийн холбоод: Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа явуулж буй салбарын хөгжил нь тэдний үйл ажиллагаатай уялддаг. Жишээлбэл: Монголын арьс ширний холбоо, Монголын ноос ноолуурын холбоо, Монголын хоршоологчдын нэгдсэн холбоо, Бэлчээр ашиглагчдын холбоо гэх мэт. Эдгээр мэргэжлийн холбоод нь салбарын хууль эрх зүй, бодлогын баримт бичиг боловсруулахад үйлдвэрлэгчдийг төлөөлж төр, олон улсын байгууллагуудтай хамтардаг. Энэхүү байгууллага нь хууль эрх зүй ба бодлогын орчныг сайжруулахад түлхүү анхаарч, бодлогын өмгөөлөл нөлөөллийн үйл ажиллагааг хүчтэй болгох, төр хувийн хэвшлийн хэлбэр төдий хамтын ажиллагаанаас бодит үр дүнд суурилсан түншлэлд хүрэхээр зорьж ажилладаг

(Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим, 2024). Гэсэн хэдий ч мэргэжлийн холбоод бүх жижиг, дунд үйлдвэрүүдэд хүрч ажиллах боломж багатай юм.

Олон улсын байгууллагууд: Олон улсын байгууллагуудаас “Ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэж, дулаан хангамжийн оновчтой системийг хэрэгжүүлэн эрчим хүчийг хэмнэх нь” “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах”, “Ази дахь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих нь”, “Хувийн секторын ажил эрхлэлт ба өсөлтийг дэмжих нь” зэрэг олон төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Эдгээрээс уул уурхайн бус үйлдвэрлэлийг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрүүдийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн төслүүд нь шууд байдлаар жижиг, дунд үйлдвэрүүдийн хөгжилд түлхэц болжээ.

Дүгнэлт, санал

Жижиг, дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагаа ковидын нөлөөнөөс хойш сэргэж эхэлсэн бөгөөд 10 хүртэлх ажилчинтай жижиг, дунд үйлдвэрүүдийн тоо буурч, ажлын байрыг нэмэгдүүлж байгаа эерэг хандлагатай байна. Нийт жижиг, дунд үйлдвэрүүдийн тал хувь нь эдийн засаг, санхүүгийн чадавх сул байгааг харуулна. Жижиг, дунд үйлдвэрүүдийн тал хувьд нь ойрын хугацаанд зээлийн хэрэгцээ үүссэн байна. Эдгээр санхүүгийн хэрэгцээ үүссэн жижиг, дунд үйлдвэрүүдийн бараг тал хувь нь банкны зээлээр шийдвэрлэдэг гэсэн нь арилжааны банкнууд жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хувьд чухал байгууллага болохыг харуулна.

Жижиг, дунд үйлдвэрүүдийн тулгамдсан асуудлуудын нэгдүгээрт, “Гадаад зах зээлд гаргах бүтээгдэхүүний чанар, стандарт, хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа байхгүй” гэсэн бол дараа нь “Маркетинг, бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлийн талаарх мэдлэг муу”, “Экспортын талаарх мэдлэг сул”, “Ажиллах хүчний ур чадвар, дутагдал”, “Санхүүжилт дутагдалтай” хэмээн эрэмбэллээ. Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын гол тоглогчид нь үйлдвэрлэгчдээс гадна

Засгийн газар, арилжааны банкууд, орц нийлүүлэгч тал болох малчид, түүхий эд худалдан авалтын гол өрсөлдөгчид болох Хятад худалдаачид байна. Иймд жижиг, дунд үйлдвэрлэгчдэд учрах эрсдэлийг бууруулахын тулд эдгээр оролцогч талуудын эерэг нөлөөг нэмэгдүүлж, сөрөг нөлөөг бууруулах шаардлагатай нь судалгаагаар нотлогдлоо.

Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд гадаад зах зээлийн чанар, стандарт, хэрэглэгчийн зан төлөвийн мэдлэг, мэдээллийг олгох судалгаанд үндэслэсэн сургалтыг зохион байгуулах, гадаад зах зээлийн борлуулалтын сувагтай тэднийг холбох зөвлөх үйлчилгээ, экспортын талаар мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулах нь ач холбогдолтой байна.

Ашигласан материал

- Монгол Улсын Их Хурал. (2019). *Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль*. Улаанбаатар.
- Монгол Улсын Засгийн газар. (2019). Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр. *156-р тогтоол*.
- Монгол Улсын Засгийн газар. (2020). Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам. *113-р тогтоол*.
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол. (2021). Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө. *42-р тогтоол*.
- United Nations Development Programme. (2019). from <https://www.undp.org>
- Ministry of Food, Agriculture, and Light Industry (MOFALI). (2024). *Official website of MOFALI*. Retrieved from <https://www.mofa.gov.mn>
- Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим. (2024). *Membership information*. Retrieved from <https://www.mongolchamber.mn/i/membership>
- Бакей, А., нар. (2024). *Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих эдийн засгийн хөшүүрэг*. Улаанбаатар: Admon Print ХХК.



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНИМ



МОНГОЛ УЛСЫН
Дотоодын
Хэрэг
Яам

Дуламзаяа, Б. (2018). Монгол Улсын
экспорт, импортын эрэлт. *Мөнгө,
санхүү, баялаг* сэтгүүл.

Жижиг, Дунд Үйлдвэрийн Газар. (2024).
Visual data on SMEs. Retrieved from
<https://sme.gov.mn/visualdata>